



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (520)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Дөлжүүдэлтэй тутмын

Улаанбаатар хот

2007 оны арваннэгдүгээр сарын 25

№43 (520)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

546.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 79	1049
547.	Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	Дугаар 80	1050
548.	М.Энхболдыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 81	1050
549.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай	Дугаар 82	1050
550.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 83	1050

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

551.	Албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 262	1051
552.	Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай	Дугаар 263	1051
553.	Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай	Дугаар 264	1053

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2007 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд

нэмэгдэл тэтгэвэр тогтоох тухай хуулийн болон "Нэмэгдэл тэтгэврийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул дээр дурдсан төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2007 он №43 (520)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дүng үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.  
2. Энэ тогтоолыг 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар  
хот

### М.Энхболдыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Миеэгомбын Энхболдыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жарантавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, санал хураалтын дүng тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн санал болгосноор Цэрэнбалтавын Сарантуяа, Банзрагчийн Пүрэвням

нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жарантавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Чоймжуурын Дашнямыг Монгол

Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 262

Улаанбаатар  
хотАлбан тушаалтын зэрэг  
дэв олгох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар аудитын итгэмжит түшээгийн Тэргүүн зэрэг зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ олгосугай.

**БОЛГОХ нь:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Бадамдоржийн Батбаярт Төрийн

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 263

Улаанбаатар  
хотПрокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах  
журам, бүрэлдэхүүнийг батлах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Прокурорын байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 42<sup>1</sup> дүгээр зүйлийн 42<sup>1.5</sup> дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

"Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг 1 дүгээр хавсралт, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧН.ЭНХБАЯР  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 263 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Прокурорын ёс зүйн зөвлөл нь /цаашид "Зөвлөл" гэх/ прокуророос ёс зүйн зөрчил гаргасан талаархи асуудлыг шалгаж, сахилгын хариуцлага хүлээгээх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мён.

1.2. Прокурорын ёс зүйн зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрэм, энэ журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаалыг удирдлагын болон үйл ажиллагаагаа улсын хэмжээнд нэгдмэл байдлаар явуулна.

1.3. Монгол Улсын Ерөнхий прокурор нь Зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшигчийг Прокурорын байгууллагын тухай хуулийн 42<sup>1</sup> дугаар зүйлийн 42<sup>1.5</sup>-д заасныг үндэслэн Ерөнхийлөгчид өргөн мэдүүлн.

1.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнээс хэн нэгнийг Монгол Улсын Ерөнхийлөгч батлахаас татгалзсан тохиолдолд Улсын Ерөнхий прокурор дахин санал оруулна.

1.5. Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуссахаас өмнө орон гарвал Прокурорын байгууллагын тухай хууль, энэ дүрэмд заасан журмын дагуу нэр дэвшүүлж нөхөн томилуулна.

**Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн болон гишүүнд төвигдэх шалгур**

2.1. Зөвлөл нь дарга, гишүүд гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь Улсын

Ерөнхий прокурорын орлогч байх бөгөөд түүний эзгүйд Зөвлөлийн даргаас эрх олгосон гишүүн Зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэн.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

2.3. Зөвлөлийн гишүүн нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршилгаргатай, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, 5-аас доошгүй жил ажилласан прокуроруудаас бүрдэнэ.

2.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь прокурор байна.

**Гурв. Зөвлөлийн эрх хэмжээ, чиг үүрэг**

3.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Прокурорын ёс зүйн зөвлөл нь прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шалглалт явуулж, дүгнэлт гаргана.

3.2. Зөвлөлийн дарга нь гишүүний эрхээс гадна дараах бүрэн эрхийг эдлэнэ.

3.2.1. Зөвлөлийн дарга нь гомдол, хүсэлтийг хүлээн авч биччэн шалгах;

3.2.2. Гомдол, хүсэлтийг харьяаллын дагуу өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

3.2.3. Прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгах гишүүн, ажлын хэсгийг томилох;

3.2.4. Шалгалтын материалтай урьдчилан танилцаж нэмэлт шалглалт хийлгүүлэхээр буцаах,



3.2.5. Шалгалтын дүнг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэх;

3.2.6. Шалгасан материалыг харьяаллын дагуу шилжүүлэх;

3.2.7. Зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хуралдааныг удирдах, өөрийн эзгүйд зөвлөлийн хуралдааныг удирдах гишүүнийг томилох;

3.2.8. Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаас гаргасан дүгнэлтэнд гарын үсэг зурж баталгаажуулах;

3.3. Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээн:

3.3.1. Прокурорын ёс зүйн хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгах;

3.3.2. Зөвлөлийн гишүүн үүрэгт ажилтай нь холбогдуулж өөрт нь илрэхий болсон, эсхүл итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах;

3.3.3. Зөвлөлийн хуралдаанд тухайн прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар санал хэлэх;

3.3.4. Зөвлөлийн даргын томилсоор зөвлөлийн хуралдааныг даргалах;

3.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүргийг хүлээн:

3.4.1. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах;

3.4.2. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтөх;

3.4.3. Шалгалтын материалыг эмхэлж архивын нэгж болгох;

3.4.4. Бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.5. Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах үндэслэлтэй байвал гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.

3.5.1. Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол;

3.5.2. Тухайн прокурортой эсхүл гомдол, хүсэлт гаргасан этгээдийн гэр бүлийн гишүүдтэй төрөл, садан байвал;

3.5.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэлтэй байгаа бол;

## Дөрөв. Гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа

4.1. Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн прокурорын газруудаас ирүүлсэн хүсэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч Зөвлөлийн даргад танилцуулна.

4.2. Зөвлөлийн дарга тухайн гомдол, хүсэлтийг хүлээн авч гишүүдэд хуваарилна.

4.3. Зөвлөлийн гишүүн гомдол, хүсэлтийг хүлээн авсан едреес хойш 30 хоногт багтаан шалгана. Хэрэв нэмэлт ажиллагаа хийг шаардлагатай тохиолдод Зөвлөлийн дарга хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгана.

4.4. Прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгахаар томилогдсон Зөвлөлийн гишүүн, ажлын хэсэг нь тухайн прокуророос Прокурорын байгууллагын тухай хууль, Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх талаар нарийвчлан шалгана.

4.5. Харин прокурор ёс зүйн зөрчил гаргаснаа өөрөө хулээн зөвшөөр тайлбарыг бичгээр гаргаж өгсэн тохиолдод тухайн тайлбар дээр үндэслэн Зөвлөлийн дүгнэлт гаргаж, Улсын Ерөнхий прокурорт танилцуулж шийдвэрлүүлж болно.

4.6. Шалгалтыг явуулахдаа албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нотлох баримт шаардан гаргуулах, тайлбар авах, хавтаст хэргээс хуулбар хийх, шалгалтын материалыг тухайн прокурорт танилцуулж тэмдэглэл үйлдэх, хариу тайлбар авах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

4.7. Дээрх ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн гишүүн, ажлын хэсэг нь шалгалтын дүнгийн талаар Зөвлөлд танилцуулга бичиж, хуралдаанд илтгэнэ.

4.8. Прокурор болон гомдол, хүсэлт гаргасан этгээд өөрийн биеэр хуралдаанд оролцох хүсэлтээ гаргавал Зөвлөлийн хуралдаанд оропцуулж тайлбарыг сонсох ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд ирээгүй бол энэ нь Зөвлөлийн хурлыг хойшлуулах үндэслэл болохгүй.

4.9. Зөвлөл нь прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг анхан шатны журмаар Зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүнтэй хэлэлцэнэ.

4.10. Зөвлөлийн дарга Зөвлөлийн гомдол ба хуралдаан даргалагчийг мөн дээрх гишүүдээс томилно. Прокурор, гомдол, хүсэлт гаргасан этгээд дээрх бүрэлдэхүүний аль нэг гишүүнээс татгалзвал Зөвлөлийн дарга шийдвэрлэнэ.

4.11. Анхан шатны журмаар асуудлыг хянан хэлэлцээд олонхийн саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

4.11.1. Прокурор ёс зүйн зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргана;

4.11.2. Нэмэлт шалгалт хийлгэхээр буцаах;

4.11.3. Холбогдох материалыг харьяаллаар шилжүүлэх;

4.12. Прокурорын ёс зүйн зөрчсөн гэж гаргасан Зөвлөлийн дүгнэлт нь сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж Улсын Ерөнхий прокурор сахилгын шийтгэлийг оногдуулна.

4.13. Анхан шатны журмаар гаргасан Зөвлөлийн дүгнэлтэнд хуралдаанд даргалагч болон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

4.14. Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийн төслийг хуралдаанд илтгэсэн гишүүн, ажлын хэсэг боловсруулна.

4.15. Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг тухайн прокурорт мэдэгдэх ба энэ тухай баримт үйлдэх, шалгалтын материалыд хавсаргах бөгөөд энэ нь давж заалдах хугацааг тоолох үндэслэл болно.



4.16. Анхан шатны журмаар гаргасан дүгнэлтийг прокурор, гомдол, хүсэлт гаргасан этгээд нь эс зөвшөөрөл мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор Зөвлөлийн даргад гомдол гаргаж болно.

4.17. Дээрх хугацаанд гомдол гаргаагүй бол уг хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор хуралдаанд даргалагч нь дүгнэлтийг Зөвлөлийн дарга, Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

4.18. Гомдлыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Зөвлөлийн бүх гишүүдийн тавиас доошгүй хувийн ирцтэйгээр дахин хэлэлцэж дүгнэлт гаргана.

4.19. Дээрх тохиолдолд Зөвлөлийн гишүүд шалгасан гишүүнээс асуулт асуух хариулт авах, шалгалтын материалытай танилцах, ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар саналаа гаргаж, санал хураалтад оролцно.

4.20. Саналыг илээр хураах ба хуралдаанд оролцсон гишүүн бүр дүгнэлт гаргах асуудлаар саналын нэг эрхтэй байна. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь зөвшөөрсөн тохиолдолд саналыг нууцаар хурааж болно. Зөвлөлийн гишүүдийн санал тэнцвэл Зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

4.21. Давж заалдах гомдлыг хэлэлцэж гаргасан Зөвлөлийн дүгнэлт нь эцсийнх байна.

4.22. Санал хураалтанд Зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцожгүй ба санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана. Хуралдааны тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргаарын үсэг зурж, тэмдэг дарна.

4.23. Зөвлөлийн бүх гишүүдийн хуралдаанаас дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

4.23.1. Анхан шатны журмаар шийдвэрлэсэн дүгнэлтийг хэвээр үлдээх;

4.23.2. Нэмэлт шалгалт явуулахаар буцаах;

4.23.3. Анхан шатны дүгнэлтэнд өөрчлөлт оруулах, дүгнэлтийг хүчингүй болгох;

4.23.4. Материалыг харьяаллаа шилжүүлэх;

4.24. Зөвлөлийн бүх гишүүдийн хуралдаанаас гаргасан дүгнэлтийг хуралдаан даргалагч 3 хоногийн дотор Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

#### Тав. Бусад асуудал:

5.1. Зөвлөлийн хуралдааны дэгийг Улсын Ерөнхий прокурор батална.

5.2. Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын Ерөнхий прокурорын газар хариуцна.

5.3. Зөвлөл Улсын Ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

5.4. Зөвлөлийн хуралдаанд оролцсон байдлыг харгалзан Зөвлөлийн гишүүдэд Улсын Ерөнхий прокурорын шийдвэрээр мөнгөн урамшуулалт олгож болно.

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны  
263 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт**

### ПРОКУРОРЫН ёС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Ч.Мөнхбат /Улсын Ерөнхий прокурорын орлогч/

Зөвлөлийн гишүүд:

1. С.Баттөмөр /ҮЕП-ын туслах, ХЭГ-ын дарга/
2. Ж.Оюунчимэг /ҮЕП-ын туслах, БТГХХ-ийн дарга/
3. Ц.Ариунболд /ҮЕП-ын туслах, ЯЭАХТХ-ийн дарга/

4. Д.Баянжаргал /ҮЕП-ын туслах, ХБАХТХ-ийн дарга/

5. Т.Сүхбаатар /НП-ын туслах, ХБАХТХ-ийн дарга/

6. Д.Сарантуяа /ҮЕПГ-ын МБАХТХ-ийн хяналтын прокурор/

7. Г.Бадамханд /СХД-ийн прокурор/

8. Б.Жаргалсайхан /Тээврийн прокурор/

9. Б.Баян-Очир /Сүхбаатар дүүргийн прокурор/

10. Б.Баасанцэрэн /Төв аймгийн прокурор/

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах  
журам, бүрэлдэхүүнийг батлах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай"  
хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Прокурорын  
байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 42

дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. "Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг 1 дүгээр хавсралт,



зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 178, 2006

оны 39, 2007 оны 62, 208 тоот зарлигудыг хүчингүйд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 264 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралт

## ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. *Нийтлэг үндэслэл*

1.1. Прокурорын мэргэжлийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мэн.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаанд шударга ёс, хууль дээдлэх зарчмыг сахиж, Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, энэ журам болон тэдгээр нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын тушаал, журмыг баримталаа.

### Хоёр. *Зөвлөлийн бүрэлдэхүүн*

2.1. Зөвлөл нь дарга, 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч байх бөгөөд түүний эзгүйд эрх олгосон зөвлөлийн гишүүн зөвлөлийн даргын үргүйг гүйцэтгэн.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын Ерөнхий прокурорын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

Зөвлөлийн бүрэлдэхүүнээс хэн нэгнийг Монгол Улсын Ерөнхийлөгч батлахаас татгалзсан тохиолдолд Улсын Ерөнхий прокурор дахин санал оруулна.

2.3. Зөвлөл нь эрх зүйн өндөр мэдлэг, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага бүхий прокурор, шүүгч болон хуульч мэргэжлийн бусад хүмүүсээс бүрдэнэ.

2.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь прокурор байх бөгөөд түүнийг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар томилно.

### Гурav. *Зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ*

3.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг 3 жилд нэг удаа шалгаж, дүгнэх;

3.1.2. Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч, туслахууд, аймаг, нийслэл, тээврийн прокурорын саналын дагуу тодорхой нэг болон хэд хэдэн прокурорын мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх;

3.1.3. Хэрэв прокурор хяналтын үйл ажиллагаанаа явцад гаргасан өөрийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэнтэй холбоотойгоор тухайн шийдвэрийн талаар мэргэжлийн үүднээс Зөвлөлийн

дүгнэлт гаргуулахыг хүссэн тохиолдолд холбогдох хэрэг, материалыг хянах дүгнэлт гаргана;

3.2. Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

3.2.1. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах;

3.2.2. Зөвлөлийн хуралдаанд дүгнэлт гаргах асуудлаар саналын эрхтэй оролцох;

3.2.3. Зөвлөлийн гишүүний үүрэг түйцэтгэхтэй холбогдон илрэхий болсон, эсхүл веер нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах;

3.2.4. Прокурорын ёс зүйн аливаа зөрчлийг илрүүлсэн тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдэгдэж шийдвэрлүүлэх;

3.3. Зөвлөлийн дарга нь гишүүний эрхээс гадна дараах бүрэн эрхийг эзлэн:

3.3.1. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах ажлыг удирдан зохион байгуулах;

3.3.2. Шалгalt хийх бүрэлдэхүүний Зөвлөлийн гишүүдээс томилох;

3.3.3. Шалгaltтын явц байдал, холбогдох материалтай танилцаж, нэмэлт үүрэг чиглэл егех;

3.3.4. Зөвлөлийн хуралдааны товыг зарлах, бэлтгэлийг хангуулах, хуралдааныг удирдах;

3.3.5. Энэ журмын 5.15-д заасан тохиолдолд Зөвлөлийн хуралдааныг дахин нэг удаа хуралдуулах;

3.3.6. Шаардлагатай гэж үзвэл холбогдох хүмүүсээс мэргэжлийн туслаалцаа авах зорилгоор шалгalt танд татан оролцуулах;

3.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүргийг хүлээнэ:

3.4.1. Энэ журмын 3.1.2-т заасан албан тушаалтнаас ирүүлсэн болон 3.1.3-т зааснаар тухайн прокуророос ирүүлсэн саналыг хүлээн авч, бүртгэл оруулан Зөвлөлийн даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.4.2. Зөвлөлийн гишүүд орон нутагт томилотоор ажиллас бэлтгэл ажлыг хариуцан зохион байгуулах;

3.4.3. Шалгaltтай холбогдуулан зөвлөлийн дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

3.4.4. Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, хуралдааны тэмдэглэл хөтлөх;



**Дөрөв.** Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажиллагаа

4.1. Энэ журмын 3.1-д заасан бүх тохиолдол нь прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг заавал шалгаж, тогтоох, дунгэлт гарахаар болно.

4.2. Нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажиллагаанд нийт гишүүдийг татан оролцуулж, арга зүйн удирдлагаар хангах ажлыг Зөвлөлийн дарга хариуцан зохион байгуулна.

4.3. Нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажиллагааг Зөвлөлийн гишүүд биечлэн гүйцэтгэх ба гишүүн бус этгээд шалгаж, дүгнэхийг хориглоно.

4.4. Журмын 3.1.2-д заасан холбогдох албан тушаалтнаас ирүүлсэн санал, эсвэл тухайн прокурорын гаргасан хүсэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, бүртгэлд оруулна. Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн нарийн бичгийн дарга нэмэлт материал шаардан гаргуулж болно.

4.5. Нарийн бичгийн дарга хүлээн авсан санал, хүсэлтийг Зөвлөлийн даргад танилцуулах ба Зөвлөлийн дарга уг санал, хүсэлтийг шалгуулахаар тодорхой нэг гишүүнд хуваарилна.

4.6. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн асуудлыг шалгуулахаар гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг томилж болох ба харин прокурор ёөрийн гаргасан шийдвэрлийг маргаж буй асуудлыг шалгуулахад 3-аас доошгүй гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг томилно.

4.7. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажлыг 30 хоногт багтаан гүйцэтгэх ба зайлшгүй нэмэлт ажиллагаа хийлгэх шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн дарга дээрх хугацаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

4.8. Зөвлөл нь прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэх ажлыг дараах 4 чиглэлээр явуулна. Үүнд:

а/ Эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох зорилгоор урьдчилан бэлтгэсэн сонжуураар шалгант авч, дүгнэх;

б/ Мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбоотой дасгал ажиллуулах замаар сэтгэн бодох чадварыг нь тогтоох, үнэлгээ өгөх;

в/ Ажил хэргийн чадвар тогтоох зорилгоор ярилцлага хийж, үнэлгээ өгөх;

г/ Хяналтын ажлын чанар, үр дүнгийн талаар судалгаа авч, ажилтай нь биечлэн танилцах замаар үнэлгээ дүгнэлт өгөх;

4.9. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэх, үнэлгээ өгөх үйл ажиллагаа нь Улсын Ерөнхий прокурорын тушаалаар тусгайлан баталсан журам, заавраар зохицуулагдана.

4.10. Прокурор ёөрийн гаргасан тодорхой шийдвэрийн үндэслэлийг хянуулахаар Зөвлөлд хандсан тохиолдолд энэ журмын 4.8 дахь хэсгийн заалт хамаарахгүй.

**Тав.** Зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэр

5.1. Зөвлөл нь прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгасан дүнг хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хуралдаанд нийт гишүүдийн 50-иас доошгүй хувь оролцсоноор ирц бүрдсэн тооцно.

5.2. Хуралдааны Зөвлөлийн дарга удирдан явуулах ба түүний эзгүйд түүнээс эрх олгосон гишүүн даргалана.

5.3. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгасан гишүүн, хэрэв ажлын хэсэг томилгдсон бол ажлын хэсгийн ахлагч шалгальтын дүнгийн талаар Зөвлөлийн хуралдаанд танилцуулах бөгөөд холбогдох танилцуула, судалгаа 3-аас доошгүй хоногийн емнэ нарийн бичгийн даргад ирүүлэх ба нарийн бичгийн дарга нь материалыг гишүүдэд урьдчилан тараах ажлыг зохион байгуулна.

5.4. Шалгальтын дүнгийн талаар гишүүд шалгальтын бүрэлдэхүүнээс асуулт асууж, хариулт авах, шалгальттай холбоотой баримт, материалы танилцах, хэрэв прокурор хуралдаанд биечлэн оролцож байгаа бол түүнээс асуулт асуух, тайлбар авах, санал бодлыг нь сонсох зэрэг хуралдааны явуулна.

5.5. Хэрэв тухайн прокурор Зөвлөлийн хуралдаанд биечлэн оролцож хүсэлтийг гаргасан тохиолдолд түүнд хурлын тогыг мэдэгдж, энэ тухай баримтгэй авах ба хундэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол түүнийг байлцуулахгүйгээр асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн.

5.6. Гүйцэтгэсэн ажлынхаа үнэн зөвийт Мэргэжлийн Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн өмнө хариуцах ба хэрэг түүний өгсөн үнэлгээ нь бодитой биш хийгдсэн, эсвэл зөрүүтэй байдал илэрвэл шаардлагатай хэрэг материалы, холбогдох баримт бичиг, мэдээ, тайланг нарийвчлан шалгаж, дүгнэлтийг өөрчлүүлн.

5.7. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, дүгнэхдээ Зөвлөлийн хуралдаанаар прокурор нэг бурийн тодорхойлолтыг сонсож, шалгальт, дасгал, ярилцлага, хяналтын ажлын үр дүнгийн үнэлгээг хэлэлцэж, гишүүн тус бурийн саналыг хурааж шийдвэрлэн. Зөвлөлийн хуралдаанаас гарах шийдвэр нь дүгнэлт хэлбэртэй байна.

5.8. Саналыг илэрхүү хураахаа ба хуралдаанд оролцсон гишүүн бүр дүгнэлт гаргах асуудлаар саналын нэг эрхтэй байна. Зөвлөлийн дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргах бөгөөд санал тэнцэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэн.

5.9. Санал хураалтад Зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцхгүй ба санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана. Хуралдааны тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

5.10. Мэргэжлийн Зөвлөлөөс тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг



үнэлээд гаргах дүгнэлт нь прокурорын албан тушаалд "тэнцэнэ" эсвэл "тэнцэхгүй" гэсэн 2 хувилбарын аль нэг байна.

5.11. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан аргачлалын дагуу дүгнэж, нийбэр дүнгээрээ 60 хүртэл оноо авсан тохиолдолд прокурорын албан тушаалд "тэнцэхгүй", 60-аас дээш оноо авсан тохиолдолд прокурорын албан тушаалд "тэнцэнэ" гэсэн дүгнэлт гаргана.

5.12. Прокурорын албан тушаалд "тэнцэхгүй" гэсэн дүгнэлт гарсан нь тухайн прокурорыг Прокурорын байгууллагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.5-д зааснаар албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болох бөгөөд Мэргэжлийн Зөвлөл энэ талаарх дүгнэлтийг Улсын Ерөнхий прокурорт хүргүүлнэ.

5.13. Прокурор гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг маргасан асуудлаар Мэргэжлийн Зөвлөлөөр хэлэлцээд гаргах дүгнэлт нь тухайн прокурорын гаргасан шийдвэрийг "үндэслэлтэй" эсвэл "үндэслэлгүй" гэсэн 2 хувилбарын аль нэг байна.

5.14. Хэрэв Зөвлөл нь тухайн прокурорын гаргасан шийдвэрийг "үндэслэлтэй" гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд дээд шатны прокурорын шийдвэрийг нь хүчингүй болгуулах, эсвэл тухайн прокурорт уг асуудалтай холбоотойгоор оногдуулсан сахилтын шийтгэлийг хүчингүй болгуулахаар Зөвлөлийн дарга холбогдох албан тушаалтанд саналаа хүргүүлнэ. Харин тодорхой

хэрэг, өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ тухайн прокурор мэргэжлийн алдаа гаргасан гэж үзсэн тохиолдолд түүнд сахилгын арга хэмжээ тооцох эсэх тухай асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, энэ тухай саналаа холбогдох албан тушаалтанд хүргүүлж болно.

5.15. Зөвлөл нь хууль, эсвэл энэ журам зөрчиж дүгнэлт гаргасан, эсвэл тухайн дүгнэлт нь Зөвлөлийн гишүүдийн хууль зөрчсөн үйл ажиллагаанд тулгуурлан гарсан гэж үзэх үндэслэлтэй бол Зөвлөлийн дарга асуудлыг өөр бүрэлдэхүүнээр шалгуулж, Зөвлөлийн хуралдааныг дахин нэг удаа хуралдуулах талаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд хуралдаанд Зөвлөлийн гишүүдийн 3/2-оос дээш хувь нь оролцож, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн.

5.16. Энэ журмын 5.15-д зааснаас бусад тохиолдолд гаргасан Зөвлөлийн дүгнэлт эцсийн байна.

### Зургаа. Бусад асуудал

6.1. Зөвлөлийн хуралдаанд оролцсон байдлыг харгалзан Зөвлөлийн гишүүдэд Улсын Ерөнхий прокурорын шийдвэрээр мөнгөн урамшуулалт олгож болно.

6.2. Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын Ерөнхий прокурорын газар хариуцна.

6.3. Зөвлөл Улсын Ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны  
264 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралт**

### МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДХҮҮН

Зөвлөлийн дарга: Б.Цэрэнбалтав -Улсын Ерөнхий прокурорын орлогч

Зөвлөлийн гишүүд:

1. Ж.Оюунчимэг - Улсын Ерөнхий прокурорын туслах, БТГХХ-ийн дарга

2. Б.Бат-Оршиг - Улсын Ерөнхий прокурорын туслах, ШТТХ-ийн дарга

3. Ц.Ариунболд - Улсын Ерөнхий прокурорын туслах, ЯЭАХТХ-ийн дарга

4. Л.Болд - Улсын Ерөнхий прокурорын туслах, МБАХТХ-ийн дарга

5. Ц.Туул - УЕПГ-ын ШТТХ-ийн хяналтын прокурор

6. Ё.Сагсай - НПГ-ын МБАХТХ-ийн хяналтын прокурор

7. Т.Баярсайхан - Баянзүрх дүүргийн прокурор

8. Б.Дашням - Орхон аймгийн прокурор

9. О.Зандраа - УДШ-ийн Иргэний танхимиын тэргүүн

10. Д.Зүмбэрэллхам - Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх

11. Д.Батсүх - Нийслэлийн Өмгөөлөгчийн холбооны емгээлэгч

12. Д.Мэндсайхан - ХЗҮТ-ийн сургалтын төвийн эрхлэгч

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

Хаяг: <>Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хасэгт хэвлэв.

Улаанбаатар- 12  
Төрийн ордон

265958  
Индекс 14003

329487

Хэвлэлийн хуудас 1